



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар A/03

ӨВТ

Г Хэсэгчилсэн хязгаарлалтын дэглэм
тогтоох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 59.1.21 дэх заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 27¹ дүгээр зүйлийн 27¹.2, 27¹.3 дах хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.5, 16 дугаар зүйлийн 16.1, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт малын гоц халдварт шүлхий өвчин малын эмчийн үзлэг, шинж тэмдэгээр батлагдсан тул 6 дугаар багийн нутаг дэвсгэрт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаагаар хэсэгчилсэн хязгаарлалтын дэглэм тогтоосугай.
2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт ажиллах хөдөлгөөнт эргүүл, хяналтын пост, тандалт судалгааны баг, хяналтын багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
3. Малын гоц халдварт шүлхий өвчин гадагш тархахаас хамгаалах, хязгаарлалтын дэглэм сахиулах, голомтын бүсэд ажиллах, хяналтын постод техник хэрэгсэл, хүн, хүч дайчлан гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой комисс (Н.Бат-Эрдэнэ)-д, шаардагдах зардлыг Гамшигаас хамгаалах сан, Мал хамгаалах сангаас гаргахыг Санхүүгийн албаны дарга (О.Отгонтуяа) нарт даалгасугай.
4. 6 дугаар багийн малчин иргэдийн байршлын зураглалыг гаргах, хүн, малын тооны судалгааг нарийвчлан гаргах, сэрэмжлүүлэг мэдээллийг өгч хязгаарлалтын дэглэмийн хууль журмыг чанд мөрдөн ажиллах талаарх иргэдийн гарын үсгийн баталгааг авч ажиллах, халдварт өвчний талаарх мэдээ мэдээллийг сумын цахим сүлжээгээр мэдээлж ажиллахыг Тандалтын багийн ахлагч тархвар зүйч (Р.Даваасүрэн), багийн Засаг дарга (Д.Дэмиддагва) нарт, голомттой бус нутгаас зорчихгүй байх, иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга (цагдаагийн ахмад Д.Энх-Амгалан), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
5. Шүлхий өвчин халдварласан байж болзошгүй малд тандалт, үзлэг хийж, ариутгал халдвартайжүүлэлтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг “Хустын рашаан” мал эмнэлэг (Л.Батбилэгт)-д үүрэг болгосугай.

•051101005

6. Хил залгаа сум, багийн малчдад халдварт өвчний талаар мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг хүргүүлэхийг багийн Засаг дарга нарт даалгасугай.

7. Голомтын бүсэд томилогдон ажиллаж байгаа албан хаагчид, голомтын бүсэд байгаа иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг хяналтанд авах, шаардлагатай эм, тарианы нөөцийг бүрдүүлэх, эрсдэлтэй бүлгийн судалгааг гаргаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Х.Цэдэндорж)-д даалгасугай.

8. 6 дугаар багийн нутаг дэвсгэр болон гадны хил залгаа аймаг, сумдаас амьд мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, мах, сүү, цагаан идээг худалдах, худалдан авахыг тодорхойгүйгээр хугацаагаар хориглосугай.

9. Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгч, байгууллагуудад үүрэг болгох нь:

а. Малын гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд нэн даруй сумын Шуурхай штабын утас 99323880 болон малын эмч, холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлэх.

б. Хязгаарлалтын дэглэмийг чанд сахин, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг дагаж мөрдөх.

10. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан ерөнхий удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Л.Батчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



Сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны
өдрийн А/03 дугаар захирамжийн хавсралт

МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШУЛХИЙ ӨВЧИНЫ ҮЕД
АЖИЛЛАХ ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛ, ПОСТ, ТАНДАЛТЫН БАГУУДЫН
ХУВААРЬ

Хөдөлгөөнт ерөнхий эргүүл:

1. Н.Загарзүсэм (Цагдаагийн тасгийн Цагдаагийн ахлагч)
2. Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
3. Ц.Нансандаваа (жолооч)

Газар нутгийн харъяалалын хөдөлгөөн эргүүл:

1. Хурцын ам Т.Эрдэнэ-Очир (малчин)
2. Хурцын их Ц.Баасанжав (малчин)
3. Шивэртий цох Ц.Галхүү (малчин)
4. Улиастайн дэнж Т.Эрдэнэбат (малчин)
5. Цагаан азарга Ц.Намжилдорж (БИНХ-ын тэргүүлэгч)
6. Горхин дэнж Жаргалсайхан (БИНХ-ын тэргүүлэгч)
7. Уурагт Ч.Гандармаа (БИНХ-ын тэргүүлэгч)
8. Бөөрөг Б.Авиддуулам (БИНХ-ын дарга)
9. Гүүр, Шийрт, Бугат, Нарийн жалга Д.Дүгэрдорж (Байгаль хамгаалагч)

Говьцэцэв
Сэжигтэй бүс:

1. Л.Батчулуун (Засаг даргын орлогч)
2. Б.Батбилэгт ("Хустын рашаан" Мал эмнэлгийн Малын эмч)
3. ~~Л.Баяр~~ (аймгийн Мал эмнэлэгийн мэргэжилтэн)

Тандалтын баг:

1. Р.Даваасүрэн (Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)
2. Г.Сугар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
3. Д.Очирхуяг (Ойн ангийн дарга)
4. П.Содномбалжир ("Хутагт уулын өгөөж" Мал эмнэлийн Малын их эмч)
5. Г.Баярсайхан (жолооч)

6 дугаар багийн иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих баг:

1. Н.Загарзүсэм (Цагдаагийн тасгийн Цагдаагийн ахлагч)
2. Х.Чулуунбат (ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргааны хэсгийн ахлагч)
3. М.Мөнхдалай (ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч)
4. Б.Авиддуулам (БИНХ-ын дарга)